**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2025 оны 11 сарын 05 өдөр Дугаар А/414 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Клиникийн бүтэц, үйл ажиллагааны 6673:2017 стандартын шаардлагын дагуу ажлын байранд хийсэн үнэлгээний дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагын нэрийг хавсралтаар батлсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

САЙД Ж.ЧИНБҮРЭН

141252175

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 11 дугаар сарын 05 өдрийн А/114 дүгээр тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

| № | Байгууллагын нэр | Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл | Хаяг байршил | Хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | “Юу Би Өү Эс Эс Ти И Эм” ХХК-ний UB OSSTEM шүдний клиник<br><br>УБД:9019075015<br>РД:5847354 | Шүдний оношилгоо,эмчилгээ,зөвлөгөө, эрүү нүүрний мэс засал, хиймэл шүдний чиглэлээр тусламж, үйлчилгээ эрхлэх | УБ хот, БЗ дүүрэг, 26-р хороо, Сакура тауэр 2 | 2030.10.28 |

---oOo---